

ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

20... он сар өдөр

Дансны №.....

Улаанбаатар

Нэмэлт нөхцөлтэй гэрээ бол хавсралтын дугаар

Нэг талаас /цаашид Банк гэх/-ийг төлөөлөндүүрэг/аймаг дахь
-ийн захирал /....., нөгөө талаас (иргэний эцгийн нэр, нэр /
хуулийн этгээдийн оноосон нэр, хэлбэр) (иргэний үнэмлэхийн дугаар/ улсын бүртгэлийн гэрчилгээний
дугаар:....., регистрийн дугаар:.....) /цаашид харилцагч гэх/ нар дор дурдсан
нөхцөлүүдийн талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Банк нь харилцагчийн хүсэлтээр харилцах данс /цаашид данс гэх/ нээж, төлбөр тооцооны үйлчилгээ /бэлэн, бэлэн бус хэлбэрээр хийх гүйлгээ/ үзүүлэх, Харилцагч нь Банкаар үйлчлүүлсний шимтгэл, хураамжийг төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.2. Харилцагч нь Банкны Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөлийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг байгуулж байгаа болно.

ХОЁР. БАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Банкны хүлээх үүрэг:

- 2.1.1 Харилцагчийн хүсэлтээр төлбөр тооцоог гүйцэтгэхдээ уг төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэрийг шалган, бүрэн тохиолдолд дансны үлдэгдэлд нь багтаан мөнгөн хөрөнгийг шилжүүлэх гүйлгээ хийх бөгөөд төлбөр тооцоог хүлээн авсан өдрийнхөө гүйлгээний цагт багтаан гүйцэтгэх;
- 2.1.2 Харилцагчийн данс, дансны гүйлгээ, үлдэгдлийн талаарх мэдээллийн нууцлалыг чанд хадгалж, хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөхгүй байх;
- 2.1.3 Харилцагч Дансаар хийгдэх гүйлгээндээ нууц үг ашиглах тохиолдолд нууц үгний бүрэн бүтэн байдал, нууцлалыг хадгалах;
- 2.1.4

2.2 Банкны эдлэх эрх:

- 2.2.1 Банкны Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл болон энэхүү гэрээний 2.1.5-д заасан хүүгийн хувь хэмжээг санхүү, мөнгөний зах зээл, үйлчилгээний хүрээ, ачаалал, харилцагчийн эрэлт хэрэгцээг харгалзан өөрчлөх;
- 2.2.2 Энэ гэрээний 4.1 дэх хэсэгт заасны дагуу харилцагчийн дансыг хааж гэрээг цуцлах;
- 2.2.3 Хуульд заасан бусад эрх;

ГУРАВ. ХАРИЛЦАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1. Харилцагчийн хүлээх үүрэг:

- 3.1.1. Гэрээ байгуулж данс нээлгэхээс өмнө Банкны Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөлтэй танилцсан байх;

Үргэлжлэл бий ...